

**УВС АЙМАГ
“ИХ БАРИЛГА УВС” ХУВЬЦААТ КОМПАНИ**

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 01

Улаангом

**“ИХБАРИЛГА-УВС”ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.9 дэх заалт, Ихбарилга увс ХК-ний дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.9 заалт, 2026 оны 04-р сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ИХБАРИЛГА-УВС” ХК-ны 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



О.М. Сумъяа

УВС АЙМАГ
"ИХ БАРИЛГА УВС" ХУВЬЦААТ КОМПАНИ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 02

Улаангом

**"ИХБАРИЛГА-УВС" ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Компаний нэрийн зөрчлийг арилгаж
"Ихбарилга" ХК болгож өөрчлөх,
дүрэмд өөрчлөлт оруулах.

Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.1 дэх заалт, Ихбарилга увс ХК-ний дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 заалт, 2026 оны 04-р сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэрийн зөрчлийг арилгахтай холбогдуулан Өмч хувьчлалын үеийн баримт бичиг, компани үүсгэн байгуулагдах үеийн бүртгэлийг орон нутаг болон Монгол Улсын ерөнхий архивын газраас шүүж үзэх, шаардлагатай бичиг баримтны лавлагаа авах, мэдээлэл цуглуулах үүрэг даалгаварыг ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  А.СҮМЪЯА



**УВС АЙМАГ
“ИХ БАРИЛГА УВС” ХУВЬЦААТ КОМПАНИ**

2026 оны 04 сарын 27-өдөр

Дугаар 03

Улаангом

**“ИХБАРИЛГА-УВС”ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө
оруулалтын дүнг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дүгээр зүйлийн 76.1.18 дэх заалт, 2026 оны 04-р сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цүнхэг төсөлд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг 500,000,000.0 (таван зуун сая) төгрөгөөр баталсугай.
2. Гүйцэтгэх захирал А. Баатарт Цүнхэг төслийн хүрээнд төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг оновчтойгоор бүрдүүлэхийг үүрэг болгож банк санхүүгийн байгууллагаас зээл авах, зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрхийг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  А.СУМЪЯА



УВС АЙМАГ
“ИХ БАРИЛГА УВС” ХУВЬЦААТ КОМПАНИ

2026 оны 04 сарын 27-өдөр

Дугаар 04

Улаангом

**“ИХБАРИЛГА-УВС”ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн
урамшуулалыг тогтоох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.3 дэх заалт, Ихбарилга увс ХК-ний дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.7 заалт, 2026 оны 04-р сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын урамшууллыг улиралд 400,000.0/Дөрвөн зуун мянга/-н төгрөг , хурлын цагийн хөлсийг нэг цагийн 8000/Найман мянга/-н төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын сарын урамшуулалыг тэдгээрийн хуралд оролцсон ирцийг үндэслэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Б. Болормаа)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (А. Сумъяа)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  А.СУМЪЯА

